

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь эрүүл мэндийн салбарт нийт 25 мэргэжлээр боловсон хүчин бэлтгэн гаргаж байна. Монгол улсын эрүүл мэндийн салбарын нийт хам олны 95 хувийг тус сургууль бэлтгэн гаргасан байна.

Хүний их эмч

АУ-аар бакалаврын боловсрол эзэмшин их сургууль төгсөж буй Хүний их эмч гэж CanMEDS-ийн үндсэн 6 үүргийг хослуулан өвчтөн, үйлчлүүлэгч төвтэй анагаах ухааны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэг өндөр мэдлэг, эмнэлзүйн үр чадвартай, мэргэжлийн ёс зүй, хандлага төлөвшсөн мэргэжилдээ жинхэнэ мэргэшисэн цогц чадамжтай хүнийг хэлнэ. Хүний их эмч нь эзэмшсэн мэргэжлээрээ мэдээллийг цуглуулж тайлбарлах, эмнэлзүйн шийдвэр гаргахад санал өгөх, оношилгоо, эмчилгээний тодорхой үйлдлүүдийг хийж гүйцэтгэх чадвартай байна. Хүний их эмч нь харилцагч, хамтрагч, зохион байгуулагч, зөвлөгч, тасралтгүй суралцагч, мэргэжилтэн хэмээх 6 үндсэн үүргийг гүйцэтгэх чадвартай байна.

Монгол анагаах ухааны их эмч

Анагаах ухааны өндөр мэдрэг оношилгооны багажаар нотолсон өвчнийг Монгол анагаах ухааны үндсэн суурь зарчимтай уялдуулан эмчлэх цогц чадамж эзэмшүүлэх, Уламжлалаа хадгалсан, уян хатан, хөрвөх чадвартай, орчин үеийн нийгмийн хэрэгцээ, ажлын байранд тавигдах мэдлэг, үр чадварыг хангасан, дэлхийн Анагаах Ухааны Боловсролын эмч мэргэжилтэн бэлтгэх суурь стандартад нийцсэн хөтөлбөр болно.

Био-анагаахын мэргэжилтэн – Молекул биологич

Анагаах ухааны судалгаа шинжилгээ мөн биотехнологийн салбарын хөгжлийг эрчимжүүлж нэн хурдацтай хөгжүүлж байгаа био-анагаахын салбар нь молекул биологийн салбар юм.

Энэхүү мэргэжлийг эзэмшсэн мэргэжилтэн нь биологийн ерөнхий процесс, үр шилжүүлэн суулгах, төрөхийн хяналт, үүдэл эсний технологи мөн түүнчлэн молекулын түвшний шинжлэх ухааны салбарт илүү мэргэшиж цаашид анагаах ухаан, эм, химийн бодис үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, мал эмнэлгийн салбарт ажиллахад шаардлагатай практик үр чадвар, онолын мэдлэгийг олж авах юм.

Био-анагаахын мэргэжилтэн – Микробиологич

Энэ мэргэжил нь халдварт өвчний үүсгэгч, ихэнхдээ бактер болон вирусыг дархлааны хариу урвалтай хамтад нь судалдаг. Мөн тархвар судлал, оношлогоо, молекул биологи, вакцинологи, биоаюулгүй болон зохицуулга гэсэн мэргэжлийн суурь болно. Халдварт өвчний үүсгэгч, ген, халдварт өвчний эмгэгжамыг танин мэдэх боломжийг олгодог. Түүнчлэн энэ нь цаашид эмнэлзүйн болон онолын суурь үндэс болдог.

Био-анагаахын мэргэжилтэн – Генетикч

Эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ерөнхий зарчим, удамшлын өвчний шалтгаан эмгэг жамд тулгуурласан оношлогоо, судалгааны арга барилыг эзэмшсэн, удамшлын ба хромосомын өвчин, төрөлхийн хөгжлийн гажгаас урьдчилан сэргийлэх ерөнхий арга зарчмыг мэддэг, энэ чиглэлээр удамзүйн зөвлөгөө өгөх чадвартай био-анагаахын шилдэг мэргэжилтэн болно.

Био-анагаахын мэргэжилтэн – Дархлаа судлаач

Энэ шинжлэх ухааныг судалснаар та дархлаа судлалыг эмнэлзүйн болон био-анагаахын шинжлэх ухаанд хэрхэн ашиглаж болохыг сурна. Мөн тархвар судлал, дархлаа оношлогоо, харшил судлал, молекул биологи, вакцин судлал, био-анагаахын мэргэжлийн суурь болно. Халдварт өвчний үүсгэгч, ген, халдварт өвчний эмгэгжам, дархлааны эмгэгийг танин мэдэх боломжийг олгодог. Түүнчлэн энэ салбар цаашид эмнэлзүй, онолын суурь үндэс болно. Сүүлийн жилүүдэд дархлаа судлалын чиглэлээр олон эрдэмтэд Нобелийн шагнал хүртсэн байна.

Био-анагаахын мэргэжилтэн – Эс судлаач

Биологи, хими, хүн судлалын шинжлэх ухаан, хүний эрүүл ба эмгэг төлөв байдал, аливаа эмгэгийн үүсэх шалтгаан механизмын тухай анагаах ухаан, эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ерөнхий зарчим, техник технологийн суурь мэдлэгийг эзэмшиж, хавдрын эрт үеийн оношлогоо, эмчилгээний үр дүнг хянах зэрэгт голлох мэдээллийг олгоно.


Эрүүл мэндийн мэдээллийн технологич

Эрүүл Мэндийн Мэдээллийн Технологич нь мэдээллийн технологийн болон техникийн шинжлэх ухаан, эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ерөнхий зарчим, технологийн суурь, судалгааны болон оношзүйн лабораторийн удирдлага зохион байгуулалтын зохих мэдлэгтэй, эмнэлгийн болон эрүүл мэндийн байгууллагуудын өдөр тутмын өгөгдлийн тусламжтайгаар мэдээллийн системийг хөгжүүлэх чадвартай, техник, технологийн мэдлэгээ ашиглан эмнэлгийн техникээр хийх үзлэгт оролцож, оношлогооны материал бэлтгэх, мэдээллийн технологийн суурь судалгаанд гүйцэтгэгчээр ажиллах чадвартай бакалаврын боловсролтой мэргэжилтэн байна.

Эрүүл мэндийн нийгмийн ажилтан

Эрүүл мэндийн нийгмийн ажилтаны бакалаврын боловсрол эзэмшсэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч буй хүн амд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх чадвар бүхий мэргэжилтэн байна.

Мэргэжлийн чиглэлийн зориулалт: Эрүүл мэндийн нийгмийн ажилтны бакалаврын боловсролын агуулга нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх түвшинд үйлчлүүлэгч хүн амын нийгэм-сэтгэл зүйн асуудал, хэрэгцээг үнэлэх, тэдний нөөц боломжийг илрүүлэх, хөгжүүлэх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, хамгаалах зорилгоор нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.



Шүдний их эмч

Нүүр ам судлалын мэргэжлийн бакалаврын зэргийн боловсрол эзэмшсэн нүүр амны их эмч нь нүүр амны түгээмэл тохиолдох өвчин эмгэгүүд, согог, гажуудын оношилгоо, эмчилгээ ба урьдчилан сэргийлэх төрөлжсөн нарийн мэргэжлийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх үр чадвар бүхий бэлтгэлтэй, эмнэлзүйн харилцааны болон гардан хийх үр чадвартай, эмчийн ёс суртахуунаар төлөвшсөн мэргэжилтэн болно.

Нүүр амны эрүүл ахуйч

Хувийн болон улсын шүдний эмнэлэг, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлэг, нийгмийн халамжийн байгууллагад нүүр амны эрүүл ахуйчаар мөн дээрхи байгууллагуудын захиргааны албанд ч эмнэлзүйн чиглэлээрээ ажиллана.

Зүү төөнө заслын их эмч

Зүү төөнө заслын эмч нь Зүү төөнө эмчилгээний болон орчин үеийн анагаах ухааны тодорхой түвшний мэдлэг, эмнэл зүйн болон оношлогоо, гардан үйлдлийн үр чадвартай, мэргэжлийн эерэг хандлага эзэмшсэн, мэдлэг үр чадвар дээр суурилан мэдээллийг цуглуулж тайлбарлах, эмнэлзүйн шийдвэр гаргахад санал өгөх, багаар хамтран ажиллах чадварыг эзэмшинэ.

Хөдөлмөрийн эрүүл ахуйч, аюулгүй байдлын ажилтан

Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын чиглэлээр оюутан төвтэй, чадамжид суурилсан сургалтаар ажлын байран дахь үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, түүнд нөлөөлөх хүчин зүйлсэд хяналт тавих, бууруулах замаар ажилчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэдлэг, практик үр чадвартай мэргэжилтэн байна.

Нийгмийн эрүүл мэнд судлалч

Нийгмийн эрүүл мэнд судлалч нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг тогтоох судалгаа хийх, эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, түүнийг арилгах, устгахад чиглэсэн ажлыг санаачлан, удирдан зохион байгуулах, хяналт тавих, олон нийтийн эрүүл мэндийг дэмжих болон хамгаалах үйл ажиллагааг салбар дундын оролцоотойгоор шийдвэрлэх мэдлэг чадвартай, анагаахын бакалаврын боловсрол эзэмшсэн мэргэжилтэн байна.

Уламжлалт Анагаахын Засалч мэргэжилтэн

Энэхүү хөтөлбөрөөр бэлтгэн гаргасан мэргэжилтэн нь уламжлалт анагаахын болон жүдо бариа заслын тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх чадвартай, уламжлалт анагаах ухаан, сэргээн засах, гэмтэл зэрэг тусламж үйлчилгээ үзүүлдэг бүх шатны эмнэлгүүд, сувилал, спортын клубуудад ажиллаж уламжлалт заслын эмчилгээ болон жүдо бариа заслын тусламж үйлчилгээг үзүүлнэ.

Сургалтын хөтөлбөрт заагдсан 25 кредитийн жүдо бариа заслын хичээлийг Японы Токио Ариаке Их сургуулийн мэргэжлийн багш нар заах ба Японы Токио Ариаке Их сургууль дээр хийх болно.

Сувилахуй

Сувилахуйн суурь мэдлэг, сувилахуйн үйл ажиллагааны гардан ажилбаруудыг эзэмшсэн, хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй байгаль, нийгэм, ахуйн орчны хүчин зүйлүүдийг үнэлж чаддаг мэргэжилтэн болж төгсөнө.

Хөдөлгөөн засалч

Хүний бие махбодийн хөдөлгөөний үйл ажиллагаа, хөдөлгөөний алдагдлыг нь сэргээн сайжруулах, тогтворжуулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх ёс хэвтүүлэх, хөдөлгөөн засал эмчилгээний стандарт үйлдлүүдийг гүйцэтгэх мэдлэг, үр чадваруудыг эзэмшинэ.

Хөдөлмөр засалч

Хүний бие махбодын танин мэдэхүй, сэтгэцийн үйл ажиллагааг үнэлж, сэргээх, хөгжүүлэх, тогтворжуулах, өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд хэвийн оролцох боломжийг бий болгох, эрүүл мэндэд нөлөөлж буй нийгэм, ахуйн орчны хүчин зүйлүүдийг зөв үнэлж амьдралын чанарыг нь дээшлүүлэх хөдөлмөр заслын суурь мэдлэг, үр чадваруудыг эзэмшсэн мэргэжилтэн юм.

Эх барихуй

Хүн амд нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, технологи үйлдлийг гүйцэтгэх мэдлэг, үр чадварыг бүрэн эзэмшсэн мэргэжилтэн болно.

Эм найруулагч

Төрөл бүрийн эмийн хэлбэр, эмийн бэлдмэлийг найруулан бэлтгэх, хэрэглэгдэхэд туслах бодисуудыг оновчтой сонгох, эмийн ургамлын түүхий эдийг бэлтгэх, эм эмийн зүйлийг хадгалах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх мэдлэг чадваруудыг эзэмшиж төгсөнө.

Нүүр амны техникч

Авагддаг болон авагддаггүй шүдэлбэр, гажиг заслын зэмсэг, эрүү нүүрний хиймэл эрхтэн бэлтгэн технологиудыг чадмаг эзэмшин төгсөнө.

Лабораторийн техникч

Олон улсын жишигт хүрсэн, судалгаа нотолгоонд суурилсан, эмнэлзүйн шинжилгээ хийх технологиудыг эзэмшин нийгмийн эрэлт хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжлийн өндөр мэдлэг чадвартай мэргэжилтэн болно.

Дүрс оношилгооны техникч

Нүний бие махбодын бүтэц үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд судалсан, эмнэлгийн дүрс оношилгооны багаж, тоног төхөөрөмжийг ажиллуулах мэдлэг, үр чадварыг эзэмшинэ.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн угсралт, ашиглалтын техникч

Эрүүл мэндийн байгууллагын шинжилгээ, оношилгоо, эмчилгээнд тоног төхөөрөмжийг суурьлуулах, засварлах, хэвийн ажиллагаагаар хангах, тохируулга хийх, оношилгоо, эмчилгээг явуулах үндсэн мэдлэгтэй, бие даан техникийн баримт бичгийг ашиглах, багаар ажиллах чадварыг эзэмшиж гарна.

Хаяг: С.Зоригийн гудамж, Ш/Х-48/111

Улаанбаатар хот 14210

Утас: 976-11-326894, 328894

Факс: 976-11-321249

Имэйл: info@mnums.edu.mn

Веб хаяг: <http://www.mnums.edu.mn>

Бүртгэл: <http://burtgel.mnums.edu.mn>